



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2023/108/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2023 он</p>	<p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас:99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас:80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Утас:99099119 Цахим хаяг:gerelthuhaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ДАЛАНЗАДГАД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 2-Р СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ч.ОТГОНБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланзадгад сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөтөмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Даланзадгад сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр 6 дугаар ангийн суралчдыг үдийн хоол хөтөлбөрт хамруулсан байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн урлагийн заалны зураг төсвийг хүлээн авч бараа материал дансны үлдэгдэл 28.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

016000015

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг захиран эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага захиран эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь захиран эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	27.8	286.6
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,739.7	2,797.2
Нийт хөрөнгийн дүн	2,767.5	3,083.8
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,767.5	3,083.8
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,767.5	3,083.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,189.6	1,616.5
Үйл ажиллагааны зардлын дүн	1,051.6	1,376.3
Үйл ажиллагааны үр дүн	138.0	240.1
Үйл ажиллагааны бус үр дүн	(4.6)	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	133.4	240.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Засгийн газрын оруулсан капитал	952.5	1,979.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	787.3	1,574.6
Хуримтлагдсан үр дүн	1,027.7	2,297.6
Эцсийн үлдэгдэл	2,767.5	5,851.4
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	926.8	1,511.2
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	920.8	1,206.1
Үйл ажиллагааны ЦМГ	6.0	305.2
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(6.0)	(75.2)
Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	230.0
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	230.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,428.7	1,192.0
Урсгал зардал	1,428.7	1,192.0
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,428.7	1,422.0
Улсын төсвөөс санхүүжих	1,301.0	1,301.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	127.7	121.0
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		230.0

Гурав. Аудитын илрүүлэлт: Аудитаар нийт 59.9 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 59.9 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа.

Аудитаар 2022.12.12-нд Аз золбоо сургалтын төвтэй англи хэлний сургалтын 4 сарын гэрээ байгуулж 5.5 сая төгрөгийг сургалтын гэрээ дүгнэлгүй тухайн өдрөө сургалтын төлбөр гэж шилжүүлээд авлага дансанд бүртгэлгүй шууд зардалд бүртгэсэн, Бат баян уул ХХК нь тайлант онд хүүхдийн өдрийн хоолыг нийлүүлж байгаа бөгөөд хүнсний материал хэсэгт орлогод бүртгэсэнтэй холбоотой 54.4 сая төгрөгийн алдааг залрууллаа

Аудитаар нийт 11.4 сая төгрөгийн зөрчил² илрүүлж тус зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

3.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй

3.3 Зөвлөмж

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуу		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлагыг данс бүртгэлд тусгаагүй	1	5,527.20			1	5,527.20	1	5,527.20				
Бараа материалыг буруу бүртгэсэн	1	54,356.21			1	54,356.21	1	54,356.21				
Дүн		59,883.41				59,883.41		59,883.41				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал										
/мянган төгрөгөөр/										
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Зөвлөмж	
			Төлбөрийн акт		Албан шаардлага					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Алдаа илрээгүй										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Төрийн хэмнэлтийн хууль	1	11400.0							1	11400.0
Дүн	1	11400.0							1	11400.0
Нийт дүн	1	11400.0							1	11400.0

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			